



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А1111

Улаанбаатар хот

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4 дэх хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын дэргэдэх "Дотоод аудитын хороо"-ны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. "Дотоод аудитын дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавих, "Дотоод аудитын хороо"-ны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхайн сайдын 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн "Дотоод аудитын хороо байгуулах тухай" 83 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ

08 0298

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2017 оны 03 дүгээр сарын 20-ны өдрийн  
АММ тоот тушаалын хавсралт

### ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дотоод аудитын хорооны дарга:

Ц.Дашдорж

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд



Гишүүд:

Г.Нандинжаргал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Д.Даваадорж

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

С.Мандахбат

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Б.Уужим-Ухаан

Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга

Б.Баатарцогт

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга

Ж.Цэвээнжав

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн зөвлөх, профессор, доктор Салбарын эрдэмтний төлөөлөл

Б.Энхтуяа

Нүүрс судлаачдын хүрээлэн ТББ-ын тэргүүн, геологич, зөвлөх инженер

Нарийн бичгийн дарга:

Ц.Одхүү

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

БАТЛАВ: УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ц.ДАШДОРЖ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



№	Дотоод аудитаар хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвийн орлого, зарлагын тооцоолол, санхүүжилтийн гүйлгээ, төсвийн тайлан тэнцэлд санхүүгийн дотоод аудит хийх	9 дүгээр сар	Ц.Одхүү Х.Цэнд-Аюуш
2	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг удирдлагын зөвлөлд танилцуулах	4 дүгээр сар	Ц.Одхүү Б.Баяржаргал Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий
3	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын хүний нөөц, боловсон хүчний чиглэлээр батлагдсан тушаал шийдвэр, бусад дүрэм, журмын хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн аудит хийх	10 дугаар сар	Ц.Одхүү Б.Баяржаргал Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий Н.Цогтбаяр
4	АМГТГ-ын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хагас, бүтэн жилээр аудит хийх	5, 10 дугаар сар	Ц.Одхүү Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий Н.Цогтбаяр
5	Гадаад сургалт, албан томилолтын зардал, төлөвлөгөө тайланд дотоод аудит хийх	11 дүгээр сар	Ц.Одхүү Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий
6	2017 оны жилийн эцсийн байдлаар яам, агентлагаас баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын сан, бүртгэлтэй холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх	9 дүгээр сар	Ц.Одхүү С.Цэцэг-Өлзий Н.Цогтбаяр
7	Салбарт хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын	12 дугаар сар	Ц.Одхүү

	төлөвлөгөөний биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Б.Баяржаргал Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий Н.Цогтбаяр Д.Батнайрамдал
8	Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус аудитыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хийж гүйцэтгэх	Тухай бүр	Ц.Одхүү Б.Баяржаргал Х.Цэнд-Аюуш С.Цэцэг-Өлзий Н.Цогтбаяр Д.Батнайрамдал